



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022. оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/749

Алтай хот

┌ Албан томилолтоор ажиллуулах ┐
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Кённам аймгийн Хадонг сумтай Говь-Алтай аймгийн Бигэр сумын хооронд хамтран ажиллах, улирлын чанартай ажлын байранд Бигэр сумын иргэдийг харилцан туршлага судлуулах, соёл, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх асуудлаар уулзалт зохион байгуулах зорилгоор Бигэр сумын Засаг даргын орлогчийг ажиллуулахаар томилсугай.

2.Албан паспорт олгуулах, томилолтоор ажилласан тухай тэмдэглэлийг холбогдох журмын дагуу заасан хугацаанд Гадаад харилцааны яаманд хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР